



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/834

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Стандарттай Ховд” хөтөлбөрийн хүрээнд ISO-9001:2015 авсан байгууллагууд хоёр дахь удаагийн магадлан аудит хийлгэх зардалд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба 2 000 000 төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газар 3 000 000 төгрөг, Зөвлөх үйлчилгээний багийн буудал, хоол, унааны зардалд 1 128 000 төгрөг, ажиллагсадын ажиллах орчны стандартыг хангах зардалд 18 172 000 төгрөгийг олгосугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 24 300 000 төгрөг /Хорин дөрвөн сая гурван зуун мянга/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.14 -д заагдсан “Стандарттай Ховд” хөтөлбөр арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 23-ны өдрийн
А/837 дугаар захирамжийн хавсралт



АЖИЛЛАГСАДЫН АЖИЛЛАХ ОРЧНЫ
СТАНДАРТЫГ ХАНГАХ ЗАРДАЛ

№	Бараа бүтээгдэхүүний нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Ширээ, сандал	1100000	8	8800000
2.	Мэдээллийн самбар	800000	2	1600000
3.	3-н үйлдэлт принтер /өнгөт/	800000	2	1600000
4.	3-н үйлдэлт принтер /хар/	800000	2	1600000
5.	Шүүгээ	586000	2	1172000
6.	Компьютерийн ширээ	680000	5	3400000
НИЙТ ҮНЭ				18172000

-oOo-